



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 13 өдөр

Дугаар А/642

Алтай хот

Өвс, тэжээлийн цэгийн манаачид  
ажлын хөлс олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, 32 дугаар зүйлийн 32.7 дахь хэсэг, аймгийн Засаг даргын 2019 оны А/136 дугаар захирамжийн 3 дугаар хавсралтын 4.2 дахь хэсэг, аймгийн Онцгой комиссын 2020 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 23 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн аюулгүйн нөөцийн өвсний бүрэн байдлыг 2019 оны 12 дугаар сарын 17-оос эхлэн хариуцан ажиллаж байгаа аймгийн төв дэх өвс, тэжээлийн цэгийн манаачийн ажлын хөлс 1826000 (нэг сая найман зуун хорин зургаан мянган) төгрөгийг аймгийн гамшгийн сангаас олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ч.Бат-Эрдэнэ)-т зөвшөөрсүгэй.

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч, Онцгой комиссын орлогч дарга (Я.Эрхэмбаяр)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ

Ж.ГАНБАТ

